

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

АГУУЛГА

1. Төслийн танилцуулга.....	2
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга.....	3
2.1. Физик газарзүй.....	3
2.2. Уур амьсгал.....	3
2.2.1. Агаарын температур.....	3
2.2.2. Хөрсний гадаргын температур.....	4
2.2.3. Хур тунадас.....	5
2.2.4. Агаарын чийгшил.....	5
2.2.5. Салхи.....	6
2.3. Агаарын чанар.....	7
2.4. Гадаргын болон газрын доорхи ус.....	9
2.5. Хөрсөн бүрхэвч.....	10
2.6. Ургамлан нөмрөг.....	10
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	11
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, цар хүрээ, тархалт.....	12
3.2. Төслийн үйл ажиллагааны эх үүсвэрээс байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийн орон зайн тархалт.....	13
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	14
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	18
7. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	18
8. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө.....	18
9. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	18
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	18
10.1. Химийн бодисын төрөл хэмжээ, хэрэглээ.....	18
10.2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
12. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	25
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	33
14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	33
15. Дүгнэлт.....	34

***“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө***

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улааны ордын холимог металл болон уран агуулсан хүдрийн биетүүд нь зэрэгцээ орших “Шинь Шинь” ХХК-ийн MV-000247, “Хунбөө” ХХК-ийн MV-013555 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайг дамнан оршдог. Иймд дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хооронд байгуулсан гэрээний дагуу “Улааны холимог металлын орд”-ыг ордын хэмжээнд нь нэгдсэн нэг далд уурхайгаар ашиглахаар 2009, 2011 онд Уул уурхайн зураг төсөл, эрдэм шинжилгээний “Бал Чулуу” ХХК-иар “Улааны холимог металлын ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл”, мөн 2015 онд боловсруулсан “Улааны холимог металлын ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотгол”-ыг хийлгэсэн бөгөөд 2018 оны нөөцийн шинэчилсэн тооцоонд тулгуурлан төслийн ТЭЗҮ-ийг 2019 онд “Прожект майнинг” ХХК шинэчлэн боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн Т/20-01-03 тоот дүгнэлтээр баталгаажуулсан байна. Улааны далд уурхайн 945 м-ээр түвшний олборлолтонд дүүргэлттэй ашиглалтын систем нэвтрүүлэхээр зорьж байгаатай холбогдуулан далд уурхайд дүүргэлттэй ашиглалтын систем нэвтрүүлэх судалгааг 2019 онд БНХАУ-ын “Бээжингийн уул уурхай, металлургийн групп” ХХК, Монгол улсын “Баялаг инженериг” ХХК-иуд хийж гүйцэтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 04-р сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн Т/19-05-05 тоот зөвлөмжийг авсан байна. Улмаар дүүргэлттэй ашиглалтын системийн Дүүргэлтийн зуурмагийн цехийн барилгын зураг төслийг 2021 онд “Татах хүч” ХХК-иар гүйцэтгүүлэн Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 08-р сарын 27-ны өдрийн 1244/2021 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажуулжээ.

“Шинь Шинь” ХХК нь “Улааны холимог металлын ордыг ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2009 онд “Алтан эко” ХХК-иар, 2015 онд “Дөрвөн талст экологи” ХХК-иар тус тус хийлгэсэн бөгөөд 2020 онд батлагдсан ТЭЗҮ-д үндэслэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шинэчилсэн тодотголын тайланг “ЕАСС” ХХК-иар гүйцэтгүүлж баталгаажуулсан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2022 оны 09-р сарын 07-ны өдөр “Шинь шинь” ХХК-д өгсөн 13/5041 тоот “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт”-ээр “Бетон зуурмагийн үйлдвэр” төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 7.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасны дагуу ерөнхий үнэлгээ хийсний үндсэн дээр тус төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж шийдвэрлэсэн байна.

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт орших Улааны холимог металлын ордыг эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Физик газарзүй

Уурхайн орд газар нь нам уулс, ухаа гүвээ, толгодоор хүрээлэгдсэн, толгодын орой хяр нь бөөрөнхий хавтгайдуу оройтой, уулын ар хажуу нь нилээд огцом, эдгээрийн хооронд нарийвтар хөндийнүүдтэй байна. Уурхай орчмын газар нутаг нь физик газарзүйн мужлалтаар Монголын дорнод талын их мужийн Дорнодын тэгш талын мужийн Хэрлэнгийн хойд талын тойрогт багтана.


2.2. Уур амьсгал

Дорнод аймгийн Дашбалбар сум орчмын уур амьсгалыг тодорхойлж, үнэлэх судалгааны ажлын хүрээнд цаг уурын Дашбалбар станцын 2010-2021 оны мэдээг ашигласан болно. /Эх сурвалж: Цаг Уур Орчны Шинжилгээний Газар, Архив Мэдээллийн Сангийн хэлтэс/

2.2.1. Агаарын температур


Агаарын сарын дундаж температурын агууриг 41.6°C байна. Үнэмлэхүй агууриг нь 45.2°C хүрдэг байна. Агаарын температур тодорхой илэрсэн жил, хоногийн явцтай байдаг. Жилийн явцад агаарын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур $+20.4^{\circ}\text{C}$ хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур -20.8°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их температур 2016 оны 8 дугаар сард $+41.4^{\circ}\text{C}$ хүрч халсан бол үнэмлэхүй хамгийн бага температур 2012 оны 01 дүгээр сард -41.7°C хүрч хүйтэрсэн байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын агаарын температурыг Дашбалбар станцын 2010-2021 оны мэдээнд тулгуурлан Зураг 1, Зураг 2-г үзүүлээ.



Зураг 1. Жилийн дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2021/

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**




Зураг 2. Сарын дундаж агаарын температурын явц /Дашбалбар сум 2010-2021/


2.2.2. Хөрсний гадаргын температур

Хөрсний гадаргын сарын дундаж температурын агууриг 48.6°C байна. Үнэмлэхүй агууриг нь 53.7°C хүрдэг байна. Жилийн явцад хөрсний гадаргын температурын их утга нь зуны 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дүгээр сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж хөрсний температур +23.9°C хамгийн хүйтэн 1 дүгээр сарын хөрсний гадаргын дундаж температур –21.1°C байна.

Үйл ажиллагаа явуулж буй талбай орчмын хөрсний гадаргын температурыг Дашбалбар станцын 2010-2021 оны мэдээнд тулгуурлан Зураг 3, Зураг 4-т үзүүлээ.



Зураг 3. Жилийн дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2021/




**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

Зураг 4. Сарын дундаж хөрсний гадаргын температурын явц /Дашбалбар сум 2010-2021/

2.2.3. Хур тунадас

Тухайн бүс нутагт жилдээ дундажаар 260 мм хур тунадас ордог байна. Уур амьсгалын дулааралт, хуурайшилтын үйл явц сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц илэрч байна. 2010-2019 онуудад тус аймагт 137.9-520.2 мм тунадас унасан байна. Жилд орох хур тунадасны дийлэнхи хувь нь зуны улиралд буюу 6, 7, 8-р саруудад ордог байна.

Жилд орох хур тунадасны нийлбэр хэмжээг 2010-2021 онуудын мэдээнд үндэслэн Зураг 5, Зураг 6-д үзүүлээ.



Зураг 5. Нийлбэр хур тунадас /2010-2021/




Зураг 6. Хур тунадасны сарын хуваарилалт /2010-2021/

Хур тунадасны жилийн нийлбэрийн сүүлийн жилүүдийн өөрчлөлтийг авч үзэхэд төсөл хэрэгжих талбайн орчмоор сүүлийн жилүүдэд буурсан хандлагатай байсан боловч 2020 онд 496.5 мм, 2021 онд 520.2 мм тунадас унасан байна.


2.2.4. Агаарын чийгшил

Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт жилийн дундаж харьцангуй чийгшил 64.2 % байна. Харьцангуй чийгшил 1 дүгээр сард хамгийн их утгатай 72.9 %, 4 дүгээр сард хамгийн бага утгатай 45.8 % болно.

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**



Зураг 7. Харьцангуй чийгшилийн жилийн явц (Дашбалбар станц, 2010-2021)



Зураг 8. Харьцангуй чийгшилийн сарын явц (Дашбалбар станц, 2010-2021)


2.2.5. Салхи

Дорнод аймаг нь хээрийн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу ховор учраас салхитай нутагт хамаарагдана. Гэхдээ хүчтэй шуургалж салхилах нь ховор. Олон жилийн дунджаас үзэхэд салхигүй намуун үе нийт ажиглалтын 15.5 хувьд байдаг байна. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг.



Зураг 9. Салхины дундаж хурдны жилийн явц /2010-2021 он/

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**



Зураг 10. Салхины дундаж хурдны сарын явц /2010-2021 он/




Зураг 11. Сүүлийн жилүүдэд ажиглагдсан салхины чиглэлийн давтагдал, % /2010-2021/

2.3. Агаарын чанар

“Шинь шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төсөл хэрэгжих орчны агаарын чанарын төлөв байдлыг тодорхойлох ажилд 2020 оны 05-р сарын 08-09-ний өдөр хийсэн агаарын чанарын хэмжилтийн үр дүнг ашиглав.

Агаарын хяналт шинжилгээний ажлын хүрээнд эх үүсвэрүүдийг нарийвчлан тогтоож, төслийн үйл ажиллагаа тогтмол явагддаг газруудад 10 цэг сонгон азотын давхар исэл, хүхэрлэг хий, том ширхэглэгт тоосонцор гэсэн үзүүлэлтүүдээр 2020 оны 05 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Нарийн ширхэглэгт тоосонцрын агууламжийг тогтооход Dusttrak Pro 8530, түгээмэл бохирдуулагч бодисуудын судалгаанд агаар сорох насос, агаарын даралт чийг, температур хэмжигч гар багаж зэрэг багаж төхөөрөмжүүдийг ашигласан.

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**



Зураг 12. Агаарын дээж авсан цэгүүдийн байршил

Хүснэгт 1. Хэмжилтийн үр дүн


№	Агаарын сорьц авсан цэгийн нэр	Байршил	Агаарын даралт	Агаарын температур	Азотын давхар исэл	Хүхэрлэг хий	Нийт тоос
			гПа	°C	мкг/м³	мкг/м³	мкг/м³
1	Уурхайн ам	49°05'05.8" 114°05'01.3"	695	13.6	14	7	63
2	Бутлуур	49°04'53.4" 114°05'54.1"	694.7	14.3	20	5	15
3	Баяжуулах үйлдвэрийн гадна	49°04'48.2" 114°05'44.4"	694.4	15	12	3	7
4	Хемпийн орчим	49°04'38.2" 114°05'49.0"	693.2	16.6	4	2	8
5	Хаягдлын сангийн орчим	49°04'58.8" 114°06'38.3"	691.9	19.2	12	7	10
6	Буцах усан сан	49°05'12.8" 114°06'38.8"	691.4	19.3	10	7	7
7	Тээврийн зам дагуу	49°04'12.8" 114°06'38.5"	690.8	19.5	15	2	13
8	Хүдрийн овоолгын хойно	49°05'09.6" 114°04'48.1"	690.5	19.8	27	3	5
9	Ус хангамжийн эх үүсвэр	49°13'29.8" 114°03'04.6"	689.2	15.8	25	4	20
10	Малчин айлын гадна	49°06'23.5" 114°06'04.4"	689	16.9	16	197	23
Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага (MNS4585:2016)					200	450	500

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

Хэмжилтийн үр дүнгээс харахад нийт тоос уурхайн амны хэсэгт хамгийн өндөр 63 мкг/м^3 , азотын давхар исэл хүдрийн овоолгын хойно хамгийн өндөр 27 мкг/м^3 , хүхэрлэг хий малчин айлын гадна хамгийн өндөр 197 мкг/м^3 байгаа боловч “Агаарын чанарын стандарт MNS 4585:2016”- аас давсан үзүүлэлт байхгүй байна.

2.4. Гадаргын болон газрын доорхи ус

“Шинь Шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг ашиглах” төсөл нь Дорнод аймгийн Дашбалбар сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж байна. Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд тус төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь Улз голын сав газарт хамаарна. Улз голын сав газрын байршлыг дараах зургаар харуулав.



Зураг 13. Улз голын сав газар

Улз голын сав газар нь Монгол орны зүүн хойд хэсэгт орших Дорнодын талд ойролцоогоор $38,000 \text{ км}^2$ -ыг эзлэн Хэнтийн аймгийн Норовлин, Батноров, Дадал, Баян-Адарга сумд болон Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Гурванзагал, Чойбалсан, Сэргэлэн, Чулуунхороот зэрэг нийт 11 сумын нутаг дэвсгэрийг дамнан оршдог. Улз голын сав газрын 89.8 хувийг Дорнод, 7.4 хувийг Хэнтий аймаг, 2.8 хувийг ОХУ-ын, мөн багагүй хэсгийг БНХАУ-ын нутаг дэвсгэрийг хамарч тогтсон байна.

Ус хэрэглээний эх үүсвэр: “Улааны холимог металлын ордын усны хэрэгцээг Сосновын экспедицийн гидрогеологийн ангийн Сэвсүүлийн голын хөндийд тогтоосон газар доорх усны ордоос хангадаг байна. Сэвсүүлийн голын хөндийн хэсэг нь төсөл хэрэгжих талбайгаас хойш 18 км зайд оршино. Тус газрын доорх усны ордын нөөц нь үйлдвэрлэлийн зэргээр $(A+B+C1) 17885 \text{ м}^3/\text{хон}$, $207 \text{ м}^3/\text{цаг}$ буюу 57.5 л/сек байна. Иймд “Улааны ордыг ашиглах” төслийн 35.8 л/сек хэрэгцээг хангах боломжтой нь харагдаж байна.

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

Сэвсүүлийн голын хөндий нь геологи-гидрогеологийн янз бүрийн түвшний судалгаанд хамрагдсан, газрын доорх усны ордын ашиглалт явагдаж байсан талбай юм. Тухайлбал, 1980-1984 онд В.А.Манукян, Е.Ф.Гаркушин, А.М.Таболина нар ус хангамжийн 2289 тоот даалгаврын дагуу ус хэрэглэгчээс 50 км радиус талбайд ус хангамжийн эх үүсвэр илрүүлэхээр Улз, Сэвсүүл, Мардайн голын хөндийд гидрогеологийн судалгаа явуулсан. Уг судалгааны ажлыг 1980-1982 онд эрлийн шатны ажлаар эхлүүлсэн бөгөөд 50 км радиус бүхий 16,238 кв.км талбайд геологи-гидрогеологийн нөхцлийг судалжээ. Гидрогеологийн урьдчилсан хайгуулын ажил 1983 оны 1-р сараас 1984 оны 6-р сарын хугацаанд хийгдсэн байна. Судалгааны ажлын цар хүрээ маш өргөн хэмжээнд хийгдсэн бөгөөд өрөмдлөг, шавхалт, болон гидрохимийн лабораторын ажлууд иж бүрнээр хийгджээ. Судалгааны үр дүнд Сэвсүүлийн голын хөндийг 2 хэсэгт хувааж нэгдүгээр хэсэн буюу Ногоон бүрдийн хэсэгт ашиглалтын нөөцийг В+С1 зэргээр 75 л/с буюу 6480 м³/хон, 2-р хэсэг буюу доод хэсгээс ашиглалтын В+С1 зэргээр 225 л/с буюу 19440 м³/хон гэж тогтоожээ.

2.5. Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайд хамаарах газар нь 920-1120 метрийн үнэмлэхүй өндөртэй нам уулс болон тэдгээрийн хоорондох бэл хөндий бүхий газарт байрлана. Төслийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрсний ангиллаар хээрийн бүлэг хөрсний Харшороон ба Хархүрэн хөрсний дэд хэвшинжид багтах чулуурхаг Харшороон, ердийн Харшороон, ердийн Хархүрэн хөрснүүд зонхилон тархсан байна. Харшороон хөрс нь үржил шимийн түвшин өндөр, Хархүрэн хөрс нь дунд зэрэг, бэлчээрт зонхилон ашиглагддаг.


2.6. Ургамлан нөмрөг

Улааны холимог металлын ордын талбайд Монгол дагуурын ойт хээрийн ургамалжилтын төлөөлөл болох Нарс – Хусан ой уулын ар, хажуу бэлээр бага хэмжээтэй тохиолдох бөгөөд энд нарс бага хэмжээтэй армаг тармаг байдалтай ганц нэгээр түлхүү тохиолдоно. Энэ нь тухайн бүс нутаг нь ойт хээрийн хамгийн өмнөд зах болохыг шууд илтгэх бөгөөд харин уул толгодоос доошлох тутам уулын хээр, нугажуу хээр нь үетэнт хээрээр солигдож уул толгод намссаар ургамлан нөмрөг Дорнод Монголын жинхэнэ хуурай хээрт шилжиж буйг илтгэнэ. Судалгааны талбайд хялганаас (*Stipa sibirica*, *S. baicalensis*), Сибирь зүр өвс (*Filifolium sibiricum*), Саман Ерхөг (*Agropyron cristatum*), Хялгасан Дэвхэргэнэ (*Arenaria capillaris*), Адамсын Шарилж (*Artemisia adamsii*), Ишгэн Шарилж (*Artemisia dracunculus*), Өлчир Шарилж (*Artemisa frigida*), Судалгүй Согоовор (*Bromus inermis*), Ширэг Улалж (*Carex duruscula*), Хөвөн оройт (*Chamaenerion angustifolium*), Цэх Түмэнтана (*Chamaerhodos erecta*), Цагаан Лууль (*Chenopodium album*), Завадскийн Тунхуу (*Dendranthema zavadskii*), Дэрвээн Хазааргана (*Cleistogenes squarrosa*), Бүхэлнавчит Багадай (*Dontostemon integrifolius*), Өмхий Шимэлдэг (*Dracoccephalum foetidum*), Нангиад Хиаг (*Elymus chinensis*), Сибирь Хиаг (*Elymus sibiricus*), Жинхэнэ Өрөмтүүл (*Galium verum*), Алтайн Согсоолж (*Heteropappus altaicus*), Томцэцэгт Дурваа (*Koeleria macrantha*), Булцуут Туйпланцар (*Phlomis tuberosa*), Ишгүй Гичгэнэ (*Potentilla acaulis*), Маралнавчит Гичгэнэ (*Potentilla tanacetifolia*) Бургаснавчит Банздоо (*Saussurea salicifolia*), Нарийннавчит Халгай (*Urtica angustifolia*), эмийн сөд (*sanguisorba officinalis*), хөх яргуй (*Pulsatilla turczaninovii*, *P. flavescens*), Одой Сараана (*Lilium pumilum*), Ацан Цахилдаг (*Iris dichotoma*), Удвал навчит тавилгана (*Spiraea aquilegifolia*), Бага алтанзул (*Heimerocallis minor*), Хавтагнавчит Хус (*Betula platyphylla*) гэх мэт зүйлүүд хээрийн судалгааны үед түгээмэл тохиолдож байв.

Ургамлан бүлгэмдэл: Төслийн талбайд д.т.д 962 -1112 м-т өргөгдсөн бэсрэг нам уулсын энгэр, бэл хажуу, хөндий, нарийн ам дагаж сөөг – үетэн – алаг өвст бүлгэмдэл, хиаг – алаг өвс – улалжит татмын нугын ургамлан бүлгэмдэл, алаг өвс - сөөгт хусан ой, үетэн - алаг өвс зүр өвст

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

нугажуу хээр, үетэн-алаг өвс-хялганат уулын хээрийн ургамлан бүлгэмдлүүд тус тус тархан ургаж байна. Төслийн талбайн ургамлан бүлгэмдлийг доорх зургаар үзүүлэв.



Зураг 14. Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх нөлөөллийг 2020 оны БОННУ-ний тайланд доорхи байдлаар үнэлсэн бөгөөд бетон зуурмагийн үйлдвэр төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор нэмэлт нөлөөлөл үүсэхгүй болно.

Улааны ордыг далд уурхайн аргаар олборлох, баяжуулах үйлдвэрийн төслөөс амьтны аймагт эерэг болон сөрөг хэд хэдэн гол ба болзошгүй нөлөөлөл үүсэх магадлалтай. Энэ бүс нутгийн махчин амьтад нь ихэвчлэн шөнийн идэвхтэй тул өдрийн цагаар махчин амьтдад үзүүлэх сөрөг нөлөөлөл харьцангуй бага ба Саарал чоно(*Canis lupus*), Мануул(*Otocolobus manul*) зэрэг зүйлүүд хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбайгаас зайлсхийх хандлагатай байхад Шар үнэг, Хярс үнэг, Халздай дорго, Дагуур зараа зэрэг зарим зүйлүүд хүний үйл ажиллагааны үр дүнд бий болсон хогийн цэг гэх мэтэд татагдаж ирэх нь бий. Мөн Цагаан зээр, Бор гөрөөс зэрэг туруутан амьтад хулгайн анчид болон махан идэшт амьтдаас зайлсхийн уурхай руу шахан байршиж элдэв халдварт өвчин тарааж болзошгүй

Далд аргаар олборлох нь хөрсөнд орногнодог мэрэгчид, мөлхөгчид, хоёр нутагтан амьтдад шууд нөлөөлөх нөлөөлөл бага байдаг ч гүний тэсэлгээний чичирхийлэл ичих процесст нөлөөлөнө. Энэ бүс нутаг түгээмэл тархацтай элбэг зүйл болох Монгол болжмор(*Melanocorypha mongolica*), Эвэрт болжмор(*Eremophila alpestris*) зэрэг жижиг шувуудын зүйл, нүүдлийн шувууд

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

баяжуулах үйлдвэрээс гарах хаягдал ус цуглуулах сан, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах уснаас ундаалснаар элдэв химийн бодисод хордох эрсдэл үүсэж болзошгүй.

“Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн эрчим, цар хүрээг тоон матрицийн аргаар үнэлж доорх хүснэгтэнд нэгтгэв.

Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээ

Гол ба болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ						
	Шинж	Эрчим	Магадлал	Тархалт	Хугацаа	Нөхөн сэргээгдэх боломж	Дүн, хэмжээ
Уурхайн тэсэлгээ болон техникийн дуучимээнээс амьтад үргэх цочих, дайжих	-1	2	3	1	3	2	-12
Амьтад бохирдсон уснаас ундаалснаар элдэв химийн бодисод хордох, өвчлөх.	-1	3	3	1	2	1	-11
Баяжмал тээвэрлэх зам амьтдын шилжилт хөдөлгөөн хийх жим, замтай давхцах	-1	1	1	1	1	3	-10
Амьтад авто машинд дайруулж үхэж үрэгдэх, гэмтэх	-1	2	2	1	1	3	-10
Уурхай туруутан амьтдын орогнох нуугдах халхавч болох	1	1	1	1	1	2	7
Махчин болон нүүдлийн шувууд ЦДАШ-ын хүчдэлд цохиулан үхэх	-1	1	2	1	1	3	-9

Нөлөөллийн үнэлгээний дүнгээс харахад Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах төслөөс амьтны аймагт нөлөөлж болох зургаан гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл байгаагаас таван нөлөөлөл СӨРӨГ ангилалд, нэг нөлөөлөл ЭЕРЭГ ангилалд багтсан.

Сөрөг ангилалд багтсан таван гол ба болзошгүй нөлөөлөл бүгд “Их” гэсэн үзүүлэлтэнд, Эерэг ангилалд багтсан нөлөөлөл, “Дунд” гэсэн үзүүлэлтэнд хамрагдаж байна. Эндээс харахад төслөөс амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл харьцангуй **ИХ** байгааг илтгэнэ.

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, цар хүрээ, тархалт

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлсэн сөрөг нөлөөллүүдийн орон зайн давхцуудыг тодорхойлон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг үнэлж тогтоон тэдгээрийн нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тодорхойллоо.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг үр дагавар түүний нөлөөллийн буурах зай, эрчимшлийг тогтооход хээрийн судалгаа шинжилгээ, хэмжилтийн дүн болон зөвлөх судлаачдын туршлагаар тодорхойлж газарзүйн мэдээллийн систем дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц” –ыг ашиглан зураглалаа.

Нөлөөлөл орон зайд буурах (F_i) функц

$$F_i = \left(1 / \left(1 + \text{Exp} \left(\left((Distance/100) - a \right) * b \right) \right) \right) * Weight$$

Үүнд:

Distance - нөлөөлөл буурах зай,

Weight - нөлөөллийн эрчим

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

a, b - налууугийн хүчин зүйлс

Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим зэрэг нь нөлөөллийн төрөл, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байх тул нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулан налууугийн хүчин зүйлсийг сонгож нөлөөлөл буурах функцийг тогтооно.

3.2. Төслийн үйл ажиллагааны эх үүсвэрээс байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллийн орон зайн тархалт

Төслийн сөрөг нөлөөллийн орон зайн тархалтын тооцолол хийхдээ эх үүсвэрээс шалтгаалсан нөлөөллүүдийг дараахи Олон улсын The Nature Conservancy байгууллагын Монгол орны хэмжээнд хийсэн Экологийн бүс нутгийн үнэлгээний тайланд тулгуурлан бүтээсэн MDT /Mongolian Offset Design/ буюу Нөлөөлөл бууруулах загвар програм ашиглан тооцлоо.

НБЗП-Десктоп нь үндсэн дөрвөн багц програмтай:

1. Land Disturbance and Impact Tools-Нөлөөллийн эх үүсвэр болон Нөлөөллийн програм
2. Offset Tools- Дүйцүүлэн хамгааллын програм,
3. Supplementary Avoidance Tools-Нэмэлт Зайлсхийх програм,
4. Update Tools-Шинэчлэх програм.

Нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөллийн програм нь хөгжлийн нөлөөллийн мэдээллийн багцыг үүсгэхэд хэрэглэгдэх Нөлөөллийн эх үүсвэрийн мэдээлэл буюу атрибут мэдээлэл, тусгаг гэх зэрэг стандартыг дагаж мөрдөхөд нь хэрэглэгчдэд тусалдаг програм юм.

Дүйцүүлэн хамгааллын програм нь нөлөөллийн өгөгдлийн багцыг ашиглаж дүйцүүлэн хамгааллын зардлын тайлан гаргаж дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрыг тогтоодог.

Нэмэлт зайлсхийх програм нь уул уурхайн болон төлөвлөсөн нөлөөллийн эх үүсвэр ба лицензтэй талбайнуудын хувьд дүйцүүлэн хамгааллын зардлыг тооцон харьцуулах боломжийг хэрэглэгчдэд олгодог. Эдгээр програмын тусламжтайгаар хэрэглэгч дүйцүүлэн хамгааллын зардлаа бууруулахаас гадна Экологийн бүс нутгийн үнэлгээгээр чухал гэж ангилсан ландшафтад хөгжлийг төлөвлөхөөс зайлсхийж болно.

Шинэчлэх програм нь хэрэглэгчдэд НБЗП-г дахин суулгалгүйгээр энэхүү програмын сүүлийн мэдээллийн санг татаж авахад тусалдаг.

2020 оны БОННУ-ний тайланд дээрхи программд нөлөөллийн эх үүсвэрүүдийг дараахи байдлаар эх мэдээлэл болгон оруулж үр дүнг гарган авсан байна.

Хүснэгт 3. Нөлөөллийн эх үүсвэр

№	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн эх үүсвэрийн код
Шугаман эх үүсвэр		
1	Хүдэр тээврийн зам	6
2	Эргэлтийн усны шугам	4
3	Хаягдал булинга дамжуулах хоолой	4
4	Цэвэр усны шугам	4
5	Бохир усны шугам	4
6	Цахилгаан дамжуулах шугам	1
7	Далд уурхайн ус татах шугам	4
8	Буцах усны хоолой	4
Талбайн эх үүсвэр		
1	Авто пүү	18
2	Агуулах	8
3	Ажилчдын амрах байр	4
4	Гаалийн хяналтын талбай	14
5	Граж	6
6	Дүүргэлтийн байгууламж	7

**“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө**

№	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн эх үүсвэрийн код
7	Дэд станц	18
8	Засварын газар	7
9	Зочид буудал	4
10	Монгол хоолны заал	4
11	Насос станц	18
12	Нүүрс буулгах талбай	8
13	Оффис	6
14	Сорьцын лаборатори	6
15	Усан оргилуур	18
16	Уурын зуух	7
17	Халуун усны байр	4
18	Харуулын байр	18
19	Химийн бодисын агуулах	8
20	Хүчилтөрөгчийн станц	7
21	Хятад хоолны заал	4
22	Цэвэрлэх байгууламж	7
23	Шохойн агуулах	8
24	Шохойн цех	7
25	ШТС	9
26	Эмнэлэг, хангамжийн оффис	6
27	Хаягдлын сан	19
28	Баяжуулах үйлдвэр	7
29	Далд уурхайн амнууд	10
30	Хүдрийн овоолго	12
31	Шимт хөрсний овоолго	12
32	Явган хүний зам, талбай	14
33	Автомашины зогсоол	14
34	Эргэлтийн усан сан	13
35	Усан сан	13
36	Далан	12
37	Эргэлтийн усны станц	18
38	Тоглоомын талбай	18
39	Цугларах талбай	18
40	Тэсрэх бодисын агуулах	8

Төслийн үйл ажиллагаа явагдаж байгаа нутагт дээр дурдсан нөлөөллийн функцуудыг ашиглан гол болон болзошгүй нөлөөллийн нэгдсэн зураглалыг гарган нөлөөлөлд өртөх газрын талбайн хэмжээг тооцов.

4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Шинь Шинь” ХХК-ийн “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын ажлыг 2020 онд гүйцэтгэн баталгаажуулсан бөгөөд тус тайлантай хамт “Шинь шинь” ХХК-ийн 2020-2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталгаажуулсан байна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд “Шинь шинь” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Улааны холимог металлын ордыг далд уурхайн аргаар ашиглах” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас хангалтгүй хийгдэж байгаа ажлууд болон “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн хүрээнд нэмэлтээр зөвлөмж болгох ажлуудыг тусгав.

***“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн
“Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны
менежментийн төлөвлөгөө***

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар Монгол Улсын хуулиуд, шинээр гарч буй шаардлагатай уялдан байнга шинэчлэгдэж байх баримт бичиг төдийгүй төслийн хэрэгжилтийн үе шатанд байгаль хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллийг тухай бүр нь бууруулж нөхөн сэргээх зорилтыг хангах үүрэгтэй юм.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд тодорхойлсон төслөөс байгаль орчин нийгэм, хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг 3-р бүлэгт тодорхойлж, нөлөөллийг бууруулах чиглэлээр хийх ажлуудыг 4-р бүлэгт зөвлөсний үндсэн дээр сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг харуулав.

“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Байгаль орчин								
Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорхи усны нөөц хомсдох	Ус ашиглах хэсгүүдийг тоолууржуулж	Ус ашиглах хэсгүүд	ш	2	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2023	БОНХ-ийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн А-156 дугаар тушаал
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
Санамсаргүй тохиолдлоор асгаралт үүсэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Асгаралтын үе хэрэглэх багаж хэрэгслээр хангаж ажиллах	Үйлдвэрийн байр, агуулах	ш	4	720’000	720’000	2023	-
	Далд уурхайн ашиглалтаас гарсан блокуудын зураглалыг гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийлгэх							
	Дүүргэлтийн бетон зуурмагийн үйлдвэрт ашиглаж байгаа цементийг битүүмжлэлтэй агуулахад хадгалан ашиглалт, зарцуулалтыг бүртгэлжүүлэн, сав баглаа боодлыг ил							

“Шинь Шинь” ХХК-ийн Улааны холимог металлын ордын далд уурхайн дүүргэлтийн “Бетон зуурмагийн үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, сая.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	задгай хаяхгүй байх							
Ургамал нөмрөгийг хамгаалах чиглэлээр								
Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох	Орчныг тохижуулж нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх	Нөлөөллийн бүсэд	га	Үйл ажиллагааны зардалд тусгах			2023	MNS 5918 : 2008
	Мод үржүүлгийн талбай, хүлэмж байгуулах	Мод үржүүлгийн талбай	ширхэг	1	4'000'000	4'000'000	2023	Байгалийн ургамлын тухай хууль 9-р зүйл MNS 6636 : 2016 MNS 6637 : 2016
Хүний эрүүл мэнд								
Байнгын хүнд, хортой нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх Байнгын хүнд, хортой нөхцөлд ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажиллагсад	Хүн	600	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах		2023	-
